



BASALTWOOL[®]
МОНГОЛ БАЗАЛТ ХК



2018

ЖИЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

4	2018 оны үр дүн	20	Бидний бүтээгдэхүүн
5	Манай компани	21	Чулуун хөвөнгийн ирээдүй
6	Түүхэн замнал	22	Ирээдүйн төлөвлөгөө
7	Хүний нөөц	23	Дүгнэлт
8	Бидний амжилт 2018 онд	24	Компанийн удирдлага
13	R&D 2018	25	Хувьцаа эзэмшигчид
16	Нийгмийн хариуцлага 2018 онд	26	Аудиторын дүгнэлт
18	Дэлхий дахинд	27	Санхүүгийн тайлан
19	Тогтвортой хөгжил		

Маргаашийн хөгжлийг өнөөдөр хамтдаа бүтээнэ.

*Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхний амар мэндийг эрэн мэндчилье!
Та бүхний өмнө 2018 оны хийсэн ажлаа тайлагнан дүгнүүлэх хариуцлагатай цаг ирж байна.*

Өнөөдөр Монгол Базальт ХК дэлхийн аж үйлдвэрлэлийн 4 дэх хувьсгал, хөгжилд оролцож эдийн засгийн үр өгөөжөөс нь хүртэх ирээдүйг ойртуулах дараагийн шатанд гарах технологи инновацийн шийдэл бүхий алхамууд хийсээр байна.

Бид Дэлхийд тэр тусмаа Төв Азийн зах зээлд өндөр технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүн экспортлогч улс болох боломж бүрдсэн байна. Иймээс бид үйлдвэрлэлдээ техник технологи, инновацийн шинэчлэл, бүтээн байгуулалтыг хийж бизнес үйл ажиллагаандаа өсөлт, дэвшил, хөгжил авчрах зорилгоор 2018 оны 5 дугаар сард компанийхаа 30 хувийг нээлттэй гарган арилжаалж санхүүжилт босгох зорилгоор “IPO” амжилттай хийлээ.

Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч та бүхнийг манай компаний хувьцаа эзэмшигч болж, инноваци шингэсэн технологи бүхий өрсөлдөх чадвартай үндэсний үйлдвэртээ хөрөнгө оруулан бидний цаашдын амжилтын түүхийг бүтээх хувь нийлүүлэгч болсонд бид гүнээ талархаж байна.

2018 онд бид дижитал санаачлага гарган компанийн дотоод ERP сүлжээ нэвтрүүлсэн, мөн олон улсын санхүү бүртгэлийн шинэ програм нэвтрүүлэн ажиллаж байна. Компанийн нэрийн

хуудас бүхий вэб хуудасныхаа нүүр цариаг шинэчилэн, харилцагч нартайгаа улам бүр ойртож ажиллахаар зорьж байна.

2019 оныг бид зогсолтгүй хөгжлийн жил гэж харж, үйлчилгээний хэв маягаа шинэчилэн, бүтээгдэхүүний чанар стандартаа сайжруулан, үйл ажиллагааны бүтээмжээ нэмэгдүүлэн, борлуулалтын орлогоо дахин 30-40 хувиар нэмэгдүүлэхээр зорьж байна.

*Хүндэтгэсэн
ТУЗ-н Дарга
Л. Ариунболд*

*Гүйцэтгэх Захирал
А. Энхгэрэл*

Борлуулалтын орлого

+89.5%

Цэвэр ашиг

3.9x

Хөрөнгө оруулалт

46.5x

Үйлдвэрлэлийн хүчин чадал

+20%

Үйлдвэрийн ээлж

2x

Шинэ бүтээгдэхүүн
үйлдвэрлэл

2

2015-2018 Борлуулалтын
орлогын өсөлт

5.1x



■ Борлуулалтын орлого (сая төг)

БИД 2007 ОНД МОНГОЛ УЛСЫН ХАМГИЙН АНХНЫ ЧУЛУУН ХӨВӨН ДУЛААН
ТУСГАААРЛАГЧ МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР БАЙГУУЛСАН



Манай компани 2000 оноос Базальт эрдэс чулуунд суурилсан дулаан тусгаарлагч материалын үйлдвэрлэлийн технологи хөгжүүлэх Эрдэм шинжилгээ судалгаа, сорил туршилтын ажлууд дээр Орос, Герман, Дани, Япон, Хятад зэрэг улсуудын Технологи хөгжүүлэлтийн Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж туршилтын үйлдвэрлэлийг амжилттай хэрэгжүүлж, Дэлхийд аравхан улс эзэмшдэг энэхүү өндөр технологийн "НОУ ХАУ"-г Монгол эх орныхоо эрдэст түүхий эд болох базальт чулуунд түшиглэн боловсруулж, өөрийн өвөрмөц орц шийдлийг гарган Монгол улсын Оюуны Өмчийн Газраар баталгаажуулан патент авч 2007 онд үйлдвэрээ ашиглалтанд

оруулан "BASALTWOOL" брэнд нэрээр Монгол улсын Барилга, Аж Үйлдвэрийн салбарын зах зээл, иргэд хэрэглэгчиддээ нийлүүлээд даруй 11 жил болсон байна.

Өнгөрсөн 11 жилийн турш бид өөрсдийн Know-How болон мятрашгүй хөгжих хүсэл эрмэлзлээ, хийсэн бүхэндээ шингээн иржээ. Бидний үүсгэн байгуулагч нар болон хамт олон хуучин арга техникийг тогтмол сорин, шинэлэг санааг туршин хөгжүүлдгийн үр дүнд бид өнөөдөр байгалийн ганц чулуунаас олон төрлийн дэвшилтэд шийдлүүдийг гарган авсан.

2007 он

Монгол Улсын хамгийн анхны базальт чулуун хөвөнгийн үйлдвэр байгуулагдсан

2009 он

Үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан, хүчин чадлаа өргөтгөсөн

2013 он

Дулааны шугам хоолойн дулаалга үйлдвэрлэх термобазальт дулаалгын үйлдвэрийг байгуулсан

2016 он

Шүршдэг базальт үйлдвэрлэх технологийг судлан Монгол Улсад анх удаа нэвтрүүлэх боломжыг нээсэн

2018 оны 5 сар

Компанийн 30%-г олон нийтэд санал болгож 6.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлэн Нээлттэй Хувьцаат Компани болсон

2018 оны 6 сар

Анхны Шүршдэг Базальт Хөвөнгийн Үйлдвэрийн Шугамыг оруулж ирсэн

2018 оны 12 сар

Галд шатдаггүй, Шавардлагатай Базальт хавтангийн технологи нэвтрүүлсэн

Бидний бүтээгдэхүүний цөмд байгалийн чулууны хүч оршино.

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбараа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг тав тухтай, барилга хийцийн эрсдэлгүй, байгальд хамгийн ойр байлгаж, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалт байлгах зорилтыг тавин ажиллаж байна.

Нийт Ажилчдийн тоо: 56



Захиргаа: 13



Үйлдвэр: 34



Борлуулалт: 9


Хүйсийн Харьцаа



66%

33%

Ажилтнуудын Насжилт



БИДНИЙ АМЖИЛТ 2018 ОНД

Үйлдвэрийн хөрөнгө оруулалт

Үйлдвэрийн засварын ажил

Үйлдвэрийн зам талбай болон дотор талбайн бетондох ажил дуусч барилгын гадна засвар хийгдсэн, агуулахын цутгалт хийгдсэн.



Машин техник


Үйлдвэрийн үйл ажиллагаанд зориулсан машин техникүүд захиалагдан ирсэн, бүрэн үйл ажиллагаанд ашиглагдаж байна.



Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэл

ШАВАРДЛАГАТАЙ БАЗАЛТ хавтангийн технологи

Хөөсөнцөр хавтанг орлох бүтээгдэхүүн, гадна фасадны дулаалга зэрэг том объектүүдийн галын болон дулаан тусгаарлагчаар ашиглах Шавардлагатай Базальт хавтанг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн.



ШҮРШДЭГ БАЗАЛТ технологийн Үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын агуулах, граж, өндөр тааз гэх мэт том объектүүдийн галын болон дулаан тусгаарлагчаар ашиглах Шүршдэг Базальт технологийн үйлдвэрийг ашиглалтад оруулсан.



БИДНИЙ АМЖИЛТ 2018 ОНД

Үйлдвэрийн хүчин чадал

Үйлдвэрийнх гарцийг цагт 1 тонноос 1.2 тонн болгож 20% нэмэгдүүлсэн бөгөөд 2019 онд гол төхөөрөмж болох зуухны шинчлэл засварын ажил хийгдэж цагт 1.5 тонн бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай болгохоор ажиллаж байна. Үүнтэй зэрэгцэн зах зээлд 2 шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлж эхлээд байна.

Үйлдвэрлэлээ тогтвортой явуулахын хажуугаар засвар шинэчлэлүүд, үйлдвэрийн өнгө үзэмж, ажиллах орчин болон технологиуд дээрээ өргөн хэмжээний шинчлэлүүд хийгдсээр байна. Энэ их ачаалалтай үед тохируулан бид хүний нөөцийн шинчлэн зохион байгуулалт хийн, үйлдвэрийн ээлжээ 2 дахин нэмэгдүүлэн ажиллаж байна.

Шилдэг байгууллага

Шилдэг ногоон технологи эрчим хүчний хэмнэлт нэвтрүүлэгч байгууллагаар шалгарсан. (БОАЖЯ, Эрчим Хүчний Зохицуулах Хороо, МҮХАҮТ, GGGI)



"Дэвшилтэт Техник Технологи бүхий Шилдэг Үйлдвэр"-Дээд Шагнал ГАРУДА 2018 шагнал хүртсэн. (2018 оны 10 сар)



БИДНИЙ АМЖИЛТ 2018 ОНД

Онцлох үйл явдал

МҮХАУТ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг оны онцлох аж ахуйн нэгжээр шалгарч МҮХАУТ-ын гадна компанийн лого бүхий тугийг мандуулсан.



“Ази номхон далайн бүс нутгийн худалдаа аж үйлдвэрийн танхимуудын холбооны Насан Туршын Худалдааны Түншээр сонгогдсон. (2018 оны 9 сар)

Дэлхийн дулаарал, Хүлэмжийн хийг бууруулж, Барилгын Эрчим хүч, дулааны алдагдлыг хэмнэх, Агаарын бохирдлыг бууруулах үйлст бодитой хувь нэмэр оруулж буйг үнэлэн Дэлхийн 27 улс орны ХАУТанхимыг нэгтгэсэн Ази номхон далайн худалдаа Аж үйлдвэрийн танхимын 2018 оны ШИЛДЭГ КОМПАНИ АЛТАН Медаль Цомыг Хүртлээ.



БИДНИЙ АМЖИЛТ 2018 ОНД

Дотоодын хамтын ажиллагаа

Агаарын бохирдлыг бууруулах Дахин дулаалга Дулаан аяны хүрээнд ЧДүүрэг, Монгол Базальт ХК хамтран ажиллах гэрээ байгууллаа. Хороо, Хэсгүүдийн дарга нарт дахин дулаалгын үр дүн, Базальтвүүл чулуун хөвөнгийн үйлдвэрийн давуу талын тухай болон иргэдэд хамтарсан сургалтыг хэрхэн явуулах аргачилал зөвлөмжийн тухай сургалт явууллаа. Иргэд Байраа дулаалснаар түлээ, нүүрс, цахилгааны хэмнэлт хийж болохыг бодит байдал дээр харуулах ажлуудыг хийхээр болов



Нийслэлийн Цэвэр Агаар Төсөл, Дулаалга аян 2 нээлтийн үйл ажиллагаа ЧД-ийн 7-р хороонд боллоо. Монгол Базальт ХК иргэдэд дахин дулаалгын үр дүнгээ танилцууллаа.

Эрдэнэт хотод борлуулалтын шинэ салбар байгуулав (Шархай Төв).



БИДНИЙ АМЖИЛТ 2018 ОНД

GIZ-ийн мэргэжлийн боловсролын сургалт ба аж үйлдвэрийн зөвлөхөөр ажиллах гэрээ байгуулсан.



Барилга Хот Байгуулалтын Яамны Сайд Х.Баделхан үйлдвэр дээр хүрэлцэн ирж, үйл ажиллагаатай танилцан, Галын эрсдлийг бууруулах, Барилгын эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, барилгын насжилтыг уртасгах талаар зөвлөлдөв.



Эрдэнэт Үйлдвэрийн "Засвар Механикийн Завод"-той хамтран энэ жилийн технологийн шинчлэл засварын ажлуудаа ЗМЗ-ддаа захиалж хийлгэхээр хамтран ажиллахаар болсон.



БИДНИЙ АМЖИЛТ 2018 ОНД

Гадаад хамтын ажиллагаа

Монгол-Японы бизнес форум эхэллээ. МонголБазальт ХК Японы Хөрөнгө оруулагч нарт Төслөө танилцуулж бна. Японы зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний танилцуулга болон энэ хугацаанд Японы технологийн лабораторид хийгдсэн туршилтын сорилын үр дүн 2020 оны Японы Токио хотод зохиогдох Олимпын Спортын томоохон барилга байгууламжид шүршдэг Базальтвүүл бүтээгдэхүүнийг галын хамгаалалтад нийлүүлэх боломжийн талаар ярилцаж бна.



Монголын Барилгын Зураг Төсөл Зохиогчдын холбоо, Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн гишүүн компаниудын улирлдлага, ИТА, архитекторууд Германы Эрчим хүчний хэмнэлт, Нарны эрчим хүчийг дулааны энергиин тооцооллын инженер,архитектор нар Монгол Базальтын сургалтын танхимд зочиллоо. Базальтвүүл чулуун хөвөн үйлдвэрлэл, дахин дулаалга, Шугам хоолой болон Барилгын дулааны алдагдалыг хэрхэн бууруулах, зураг төсөлд чулуун хөвөнг хэрхэн хэрэглэх талаар сургалт, харилцан ярилцлага зохион байгууллаа. Германы инженерүүд Монгол Базальт Компани Эрчим хүчний хэмнэлтийн Евро Стандартыг хөгжүүлж буйг сайшаалаа.

Солонгос Улсын MLD PLUS Co.,Ltd захирал Ким Жанг Монголд Барилгын салбарт олон жил төсөл хэрэгжүүлж буй туршлагатай нэгэн. Хамтрагч RNC Group ceo Richard Kim-ын хамт Монгол_Базальт ХК-д зочилж Хан Уул дүүрэгт хэрэгжүүлэх 10 000 айлын орон сууцныхаа төсөл, хөтөлбөрийнхөө талаар танилцуулж Basaltwool дулаалгадаа хэрэглэхээр зургандаа тусгасан ба хамтарч ажиллахаар зөвлөлдлөө.



БИДНИЙ АМЖИЛТ 2018 ОНД

БНХАУ-ын ICBC банкны Монгол Улс дах суурин төлөөлөгчийн газрын удирдлагуудтай шинэ үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх ажлаа эхлүүлээ.



Шинэ үйлдвэрийн төслийг БНХАУ, Япон болон манай 3 улсын гадаад хамтын ажиллагааны стратегийн ач холбогдолтой төсөл хэмээн Гадаад Харилцааны Яамны Сайд Д.Цогтбаатар хүлээн авч уулзав.



БНХАУ-ын технологи инновацийн хөрөнгө оруулагч New Time Foundation, БНХАУ-ын чулуун хөвөнгийн №1 компанийн захирал Жанг, Япон Улсын Chogai Trade компанийн зөвлөх инженер, Чулуун хөвөнгийн үйлдвэрийн технологийн дэлхийн топ инженер Вада сан нар Монгол Базальт компанийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг хэрхэн хамтран хөгжүүлэх, Япон болон БНХАУ -руу бүтээгдэхүүн экспортлох төлөвлөгөөгөө гаргалаа.



2018 оны 11 сард БНХАУ Шанхай хотод болсон Олон Улсын Эрчим Хүчний хэмнэлттэй дулаалгын материалын хамгийн том үзэсгэлэн TIM Expo-д оролцож дэлхийн 50 улсын 25,000 орчим үзэгчдэд бүтээгдэхүүнээ танилцууллаа.


TIM Expo
Shanghai
Since 2003



СУДАЛГАА БА ХӨГЖИЛ

Эрдэм Шинжилгээ, Судалгаа хөгжүүлэлт

2018 оны 10 дугаар сард ОХУ-ын Уралын Холбооны Политехникийн Их сургуультай эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны гэрээ байгуулан Эрдэс түүхий эдийг хайлуулах, "Монгол Базальт ХК"-ийн чулуун хөвөнгийн хайлах зуухны дулааны горимыг болон хийцийг өөрчлөн шинэчлэж сайжруулах тооцоо, судалгааг эхлүүлээд байна. Дээрх тооцоолол судалгааны дагуу 2019 онд хайлах зуухны технологийн шинэчлэл, модернизацийн ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн.



2018 оны 10 дугаар сарын 18-19 хооронд ОХУ Москва хотод 3 дах удаагаа болсон Олон Улсын Базальт Тех Форумд Монгол Улсаас анх удаагаа илтгэгчээр уригдсан.

Базальт мяндас технологийн ирээдүй Дэлхийд Шинэ зууны Шинэ композит материалын ирээдүйг бий болгож байна. Монгол Базальт ХК базальт утас хийх туршилтаа амжилттай хийлээ.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА 2018 ОНД

Дахин Дулаалга ба Эрчим Хүчний Хэмнэлтийн Сургалт

Улаанбаатар хотын 3 дүүрэг (ЧД, СХД, БГД)-ийн 40 хороонд Дахин Дулаалга ба Эрчим Хүчний Хэмнэлтийн Сургалтыг зохион байгуулж дахин дулаалга хийх айлуудад зөвлөгөө өгсөн.



Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо: **150,000**

Мишээл Экспод байрлах компанийн Show-room-д долоо хоног бүр Эрчим Хүчний Хэмнэлт, Галын эрсдлээс урьдчилан сэргийлсэн барилга, Ногоон Барилга ба Зураг Дизайн, Дахин Дулаалга ба агаарын бохирдлыг бууруулах нь сэдвүүдээр сургалтууд зохион байгуулсан.



Дахин Дулаалгын Төслийн хэрэгжилт

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Нийслэлийн орчны бохирдлыг бууруулах зорилгоор дахин дулаалгын эхний **50** айл төсөлд хамрагдсан.

Дахин дулаалгын үр дүнд нэг айлын нүүрсний хэрэглээ дунджаар **60%**-иар буурсан ба 1 дүүргийн **260** гаруй иргэний амьдрах орчинг сайжруулсан.



Базальтвүүлийн 2018 оны азтангуут

Улирал тутам цахим орчинд азтан шалгаруулж чулуун хөвөн дулаалгын материалын эрхийн бичиг гардуулж өгдөг уламлалтай болсон.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА 2018 ОНД

Эрчим хүчний хэмнэлттэй Пассив Гэр төсөл

Сонгинохайрхан дүүрэгт "ГэрХаб" ТББ-тай хамтран дулаалга, халаалт, агааржуулалт, бохирыг цогцоор нь шийдсэн эрчим хүчний хэмнэлттэй Пассив Гэр төслийг туршилтаар хэрэгжүүлсэн.



Төслийн үр дүнд гэрийн эрчим хүчний хэрэглээ болон CO2 ялгаруулалт жилд 82%-р буурч, жилийн дулаалга болон эрчим хүчний зардал 75% буурч, дахин боловсруулалт 10%-с 70% болж нэмэгдсэн үр дүнтэй байна.



Дахин Дулаалгын Төслийн Санхүүгийн Хамтрагчид

Айл бүрт 15 сая хүртэл төгрөгийн дүнтэй дулаалгын материалын зээл олгох үйлчилгээ анхлан ХААН Банктай хамтран нэвтрүүлсэн.

Айл бүрт 5 сая хүртэл төгрөгийн дүнтэй дулаалгын материалын зээл олгох үйлчилгээ анхлан ХАС Банктай хамтран нэвтрүүлсэн.



Цаашдийн хамтын ажиллагаа

Ирэх жилүүдэд хийгдэхээр төлөвлөгдөж буй Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах төслийн хүрээнд 10,000 айл дахин дулаалах төслийн судалгаанд хамтран ажиллаж байна.

төслийн хүрээнд 10,000 айл дахин дулаалах төслийн судалгаанд хамтран ажиллаж байна.

ДЭЛХИЙ ДАХИНД



12 жил

Дэлхийн дулаарлын өсөлтийг аж үйлдвэрлэлийн хувьсгалын өмнөх төвшнөөс 1.5°C хүртэл хэмжээнд барьж уур амьсгалын өөрчлөлт гамшгийн төвшинд хүрэхээс сэргийлэх хүртэлх үлдсэн хугацаа.



1/3

Барилгын салбар нь дэлхийн хог хаягдлын гуравны нэгийг бүрдүүлдэг бөгөөд үүний дийлэнх нь дахин боловсруулагдалгүй хаягдал болж байна.



6.7 тэрбум

2050 он гэхэд нийт дэлхийн хүн амын хот суурин газарт амьдрах хүн амын тоо одоогийн 55%-иас (4.2 тэрбум) 68% болж нэмэгдэх ба дэлхий даяар эрчим хүч, дэд бүтцийн хомсдолд орно.



15 : 60 литр

1 кг улаан лоолийг тариалахад хэрэгцээт усны хэмжээ ил газар тарихад 60 литр шаардлагатай байдаг бол хүлэмжид чулуун хөвөнд тариалахад 15 литр ус хангалттай.

Тогтвортой хөгжлийн зорилтууд

Дэлхий даяар тулгамдаад буй эдгээр асуудлуудыг тогтвортой арга замаар шийдвэрлэхийн тулд Нэгдсэн Үндэсний Байгууллага нь 2030 он хүртэлх 17 Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг тунхагласан бөгөөд дэлхийн томоохон аж ахуйн нэгжүүд өөрсдийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж эхлээд байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Уур амьсгалын өөрчлөлтөнд Basaltwool бүтээгдэхүүн хэрхэн нөлөөлөх

BASALTWOOL тусгаарлагч бүтээгдэхүүнүүд бол нүүрсхүчлийн хийн хаягдлыг багасгах хамгийн гол эх үүсвэр юм. Данид 250 мм-ын Basaltwool дээврийн тусгаарлагчтай барилга нь 50 жилийн турш ашиглахдаа тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, ашиглалтанд зориулснаас 162 дахин их нүүрсхүчлийн хийг хэмнэх боломжтой гэж үзэж байна. Нүүрсхүчлийн хийн тэнцвэржилт BASALTWOOL бүтээгдэхүүн хэрэглэж эхэлснээс хойш 4 сарын дараа эерэг болох юм.

Агаар бохирдлыг багасгахад Basaltwool бүтээгдэхүүн хэрхэн нөлөөлөх

Эрүүл амьдрахад эрүүл агаар хангалттай байх шаардлагатай. Түлш шатаалт бол агаарын бохирдлын олон төрлийн эх үүсвэр болдог. Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллагын мэдээнээс үзэхэд том хотуудад автомашин, тээвэр, цахилгаан эрчим хүч болон хүний бусад хэрэглээнд зориулагдсан түлшний шаталтаас үүссэн агаарын бохирдлоос болж жил бүр 800,000 гаруй хүн амиа алдаж байгаа аж.

BASALTWOOL бүтээгдэхүүнээр дулаалснаар нэг айлын дулаандаа зарцуулдаг нүүрсний хэрэглээ дунджаар 60%-иар буурсан ба CO2 ялгаруулалт жилд 82%-р буурах боломжтойг бид туршилтаар тогтоогоод байна.



Тогтвортой хөгжлийн зорилт

Монгол Базальт ХК нь өөрийн нийгмийн хариуцлага болон бизнесийн үйл ажиллагаандаа Нэгдсэн Үндэсний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг мөрдлөг болгон ажиллахаар зорьж байна.

Бид Тогтвортой хөгжлийн зорилтуудын 3, 9, 11, 12, 13 дугаар зорилтуудыг хангаж ажиллахаар зорих ба дэлхий дахины ирээдүйн тогтвортой хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулах болно.

Бидний гол бүтээгдэхүүн болох Базальт чулуун хөвөн нь дулааны алдагдлыг бууруулаад зогсохгүй үйлдвэрлэлийн явцад гарсан хаягдалыг дахин боловсруулах боломжтойгоороо давуу талтай.



БИДНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН



BASALTWOOL® **ЧУЛУУН ХӨВӨН** **ХАВТАН**




ШУГАМ ХООЛОЙН **ДУЛААЛГА**



BASALTWOOL® **ХЭСЭГЧЛЭН** **УГСРАХ СЭНДВИЧ**



BASALTWOOL® **ХАВТАН** **ФАЙБЕР ЦЕМЕНТЭН** **ГАДАРГУУТАЙ**



ЧУЛУУН ХӨВӨНГИЙН ИРЭЭДҮЙ

ТАРИАЛАН

Гидропоник газар тариаланд байгалийн цэвэр базальт чулуун хөвөн материалыг ашиглаж байна.

Эрдэст чулуун хөвөнг хөрс болгон хэрэглэснээр, байгалийн эрдэс бодисыг натурал аргаар ургамалд хүргэж чаддаг бөгөөд **ургацын хурдыг нэмэгдүүлдэг.**



АРМАТУР

Базальт мяндсан материал нь химийн урвалд ордоггүй, физик шинж чанараа маш удаан хугацаанд алддаггүй тул зэврэх гэх мэт химийн болон физикийн доройтолд ордоггүй тул хатуу хучилттай замын эдэлгээг 47%-аас илүү нэмэгдүүлдэг байна.

Иймээс хөгжингүй орнуудад дэд бүтцийн шинэчлэлт хийхэд ганг орлох тэргүүний материал гэж үздэг байна.

BASALT FIBER

Базальт мяндсан материал нь гантай харьцуулахад **4 дахин хатуу** боловч **3 дахин хөнгөн** учир илүү хөнгөн бөгөөд өртөг багатайгаар гантай тэнцэх хатуу материал болгон орлох боломжтой.

Базальт мяндсан утас нь Нүүрстөрөгч мяндас (Carbon Fiber)-тай харьцуулахад **3-5 дахин хямд өртөгтэй**, эдэлгээ сайн даадаг чанар нь давуу талтай.



2019 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

₮ 5.4 тэрбум буюу 2018 оноос 55%-иар нэмэгдүүлэх

ЦЭВЭР АШИГ

₮ 590 сая буюу 2018 оноос 172%-иар нэмэгдүүлэх

2022 ОН ХҮРТЭЛХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

БРЭНДИНГ ХӨГЖҮҮЛЭЛТ

- BASALTWOOL® брэндийг зорилтот зах зээлд, хэрэглээний өргөн сонголттой, техникийн давуу шийдэлтэй, үнээр өрсөлдөх чадвартайгаар дотоодын болон гадаадын зах зээлд амжилттай нэвтрүүлэх
- Төв Азийн Базальт Дулаалгын Материалын №1 үйлдвэрлэгч, борлуулагч болох

БОРЛУУЛАЛТ

- 2017 оны борлуулалтыг 50% өсөлттэйгөөр төлөвлөж байгаа ба цаашид 2022 он хүртэл жил бүр дунджаар 45%-ийн өсөлт гаргах
- 2022 онд компанийн нийт борлуулалтыг 14 тэрбум төгрөг болгож 2017 оны гүйцэтгэлээс 7 дахин өсгөх
- Гадаад зах зээл дээр BASALTWOOL® брэндийн дистрибьюторын үйл ажиллагаас эрчимжүүлэн тэлэх
- Гадаадын экспортын зах зээлд бүрэн нэвтэрч байр сууриа тогтоон, 2021 он гэхэд борлуулалтын 50%-60%-ийг бүрдүүлдэг болох
- Дотоод зах зээл дээр тэргүүлэгч байр суурийг тогтоон, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарттай бүтээгдэхүүн үйлчилгээг дотоодын хэрэглэгчдэд олгох

ЧАНАР

Бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах, олон улсын ISO 9001:2015 стандартыг 2020 он гэхэд нэвтрүүлэх

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

-BASALTWOOL® брэндийн онцолсон 5 бүтээгдэхүүн болох

1. Чулуун хөвөн хавтан (batts)
2. Чулуун хөвөн уян (flexible)
3. Чулуун хөвөн шүршдэг (spray wool)
4. Чулуун хөвөн шугам хоолой (pipe)
5. Чулуун хөвөн шавардлагатай (cement mortar BASALTWOOL®)-ний чанарын хяналтыг тогтмол барин тогтворжуулан, зах зээл бүрдээ тохирсон бүтээгдэхүүний хэрэглээний стандарт арга зүйг таниулан нэвтрүүлэх.

МОНГОЛ БАЗАЛТ ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол Базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2018 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулах, түүхий эд материалын бэлтгэлийн ажлыг сайн зохион байгуулах, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулах, бүтээгдэхүүний тоо хэмжээг төрөлжүүлэх, дотоод/гадаадын борлуулалтын сувгуудын тогтолцоог сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн билээ.

Монгол Базальт ХК 2018 онд 3.4 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж бизнес төлөвлөгөөний биелэлт 142%, цэвэр ашиг 217 сая төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 637%-иар өссөн гүйцэтгэлтэй гарлаа.

Түүхий эд бэлтгэл өмнөх 2017 оноос 34%-иар нэмэгдүүлж, нийт 3500 тонн түүхий эд бэлтгэсэн байна.

Монгол Базальт ХК тайлант хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж дээр 16,925,100 ширхэг хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгож нийт 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татан төвлөрүүлснээс 3.6 тэрбум төгрөг буюу 56.2%-ийг чулуун хөвөнгийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжүүдийн шинэчлэл өргөтгөл, үйлдвэрийн барилгын өргөтгөл, шинэчлэлт, үйлдвэрт ашиглах машин механизм болон бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна.

Мөн 2018 онд олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалт болон ОХУ-н Уралын Политехникийн Их сургуультай эхлүүлсэн Эрдэм шинжилгээний ажлын эхний үр дүнд үйлдвэрлэлийн бүтээмжийг 20%-иар нэмэгдүүлэн цагт 1 тонн үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг цагт 1.2 тонны гарцад хүргэсэн байна.

Иймд Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2018 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

МОНГОЛ БАЗАЛТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

КОМПАНИЙН УДИРДЛАГА

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд

Лхагважавын
АРИУНБОЛД



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Цахиурын исэлд
суурилагдсан
эрдэсийн хайлах
болон дулаанаар
боловсруулах
технологийн
үйлдвэрийн инженер,
Эдийн Засагч

Галбадрахын
ГАНЗОРИГ



Цэргийн
командлагч,
Улс төр
судлаач

Ариунболдын
ЭНХГЭРЭЛ



ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Үйлдвэр Үйл
ажиллагааны
Менежмент,
Санхүү
Менежмент

Пүрэвбанзрагчийн
САЙНБИЛЭГ



САНХҮҮ ЭДИЙН
ЗАСГИЙН ХЭЛТСИЙН
ЗАХИРАЛ Технологийн
Инженер, Санхүүч

Ширэндэвийн
БАТЖАРГАЛ



Нягтлан
Бодогч,
Компанийн
Засаглалын
мастер

Бадарчийн
ШАРАВСАМБУУ



Нягтлан бодогч,
Гавьяат Эдийн
засагч

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд

Шаравсамбуугийн
ЭНХТӨР



Төлөөлөн удирдах
зөвлөлийн хараат
бус гишүүн

Түвшинтөрийн
ЦЭНД-АЮУШ



Төлөөлөн
удирдах
зөвлөлийн
хараат бус
гишүүн

Чансаагийн
ЗОРИГБААТАР



Төлөөлөн удирдах
зөвлөлийн хараат
бус гишүүн

ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 нь хараат бус гишүүн юм.

2018 оны 7 сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас томилогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодыг байгуулан ажиллаж байна. ТУЗ өнгөрсөн онд хуралдаж компанийн гүйцэтгэх захирал томилох, ТУЗ-ийн даргыг томилох, хороод байгуулах шийдвэр тус тус гаргасан бол энэ оны 1 дүгээр улиралд 3 удаа хуралдаж аудитын компанийг сонгох, ногдол ашиг тараах, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам батлах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуудах гэх мэт 12 тогтоол шийдвэрийг гаргасан байна. ТУЗ-ийн тогтоол шийдвэрийг Монгол хөрөнгийн биржийн цахимт хуудсан нийтлээд байна.

ТУЗ-ийн гишүүдийн Монгол Базальт ХК-ийн хувьцааг эзэмшсэн байдал	
Л.Ариунболд	20,140,869 ширхэг (35.7%)
П.Сайнбилэг	7,503,461 ширхэг (13.3%)
А.Энхгэрэл	3,949,190 ширхэг (7%)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Компанийн хувьцааны код: **MBW**
Арилжаалагдах бирж: **Монголын Хөрөнгийн Бирж**
Нийт хувьцааны тоо: **56,417,000**
Хувьцаа эзэмшигчдийн тоо: **2,374 (ҮЦТХТ)**
Хувьцааны төвлөрөл: **70%**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

“Монгол Базальт” ХК нь 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдөр анхдагч зах зээлийн арилжаагаа амжилттай хааж, нийт 3102 хувьцаа эзэмшигчидтэй, нээлттэй хувьцаат компани болсон билээ. Улмаар 2018 оны 7 сарын 27-нд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлаж 89%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдсан. Хурлаар 2018 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн 41 хоногийн дотор хийгдсэн ажлуудыг танилцуулах, хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлуудыг хэлэлцэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус

хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн баталсан асуудлууд:

1. Компанийн шинэчилсэн дүрэм батласан
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгосон
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоосон.



2019 ОНЫ “ТОП-20” ИНДЕКСИЙН САГСАНД БҮРТГЭГДЛЭЭ



Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын дагуу ТОП-20 индексийн багцыг 2019 онд бүрдүүлэх үнэт цааснуудыг шалгаруулж, “Монгол Базальт” ХК нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна. Шинэчилсэн сагсын дагуу индексийн тооцооллыг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэлсэн.



Аудит, нягтлан бодох бүртгэл,
 санхүүгийн зөвлөгөөний
 итгэмжлэгдсэн байгууллага

**"МОНГОЛ БАЗАЛТ" ХК-ИЙН
 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид "Монгол базальт" ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон бусад тайлангуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар "Монгол базальт" ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь бүхий л материалаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцжээ ажлаах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудиторын үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажлалд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх, түүвэр шалгалтын арга ашиглан магадлах ажил багтана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц материаллаг алдаа илрээгүй.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулах нь Удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагатай байна.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэнд баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан эсвэл алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа бий юм.



ЗАХИРАЛ

Ж.ОЮУНБИЛЭГ

Санхүү байдлын тайлан

Тайлант үе: 2018/01/01 - 2018/12/31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	115,260,008.65	3,909,193,050.58
1.1.2	Дансны авлага	330,337,195.71	322,464,676.70
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	40,001,163.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	418,024,382.62	652,795,002.01
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	3,662,442.00	1,594,737,498.75
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	867,284,028.98	6,519,191,391.04
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	19,388,943,784.51	19,993,300,584.73
1.2.2	Биет бус хөрөнгө	2,801,530,739.73	2,802,385,123.29
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	22,190,474,524.24	22,795,685,708.02
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,057,758,553.22	29,314,877,099.06
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	419,972,273.17	130,141,344.79
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	271,236,015.70	149,119,292.89
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	1,195,827,123.29
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	18,000,000.00
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	203,400,000.00	203,400,000.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богнио хугацаат өр төлбөрийн дүн	894,608,288.87	1,696,487,760.97
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	496,547,513.00	0.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	496,547,513.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,391,155,801.87	1,696,487,760.97
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	0.00	0.00
2.3.2	Хувийн өмч	3,949,190,711.00	5,641,700,000.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	17,103,804,011.94	21,145,915,459.34
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	613,608,028.41	830,773,878.75
2.3.11	Эздийн өмчийн дүн	21,666,602,751.35	27,618,389,338.09
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	23,057,758,553.22	29,314,877,099.06

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



А.ЭНХГЭРЭЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Хэмжээ: 2019/01/29 19:17

Хуудас: 1/1

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайланг үе: 2018/01/01 - 2018/12/31

Мөрний дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайланг жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,835,813,082.48	3,478,295,610.00
2	Борлуулалтын өртөг	1,461,277,241.81	2,640,415,245.68
3	Нийт ашиг (алдагдал)	374,535,840.67	837,880,364.32
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	51,289.26	339,791,434.90
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	25,632,715.56	16,461,000.77
9	Борлуулалт, маркетингийн зардал	130,743,231.95	452,870,568.53
10	Ерөнхий ба удирдлагын зардал	171,099,433.69	407,200,080.66
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	64,061,058.40	80,801,014.11
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-7,300,674.17	-2,116,142.86
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	65,319,100.51	251,144,993.83
19	Орлогын татварын зардал	9,665,333.80	33,979,143.49
20	Татварын дараах ашиг (алдагдал)	55,653,766.71	217,165,850.34
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	55,653,766.71	217,165,850.34
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	55,653,766.71	217,165,850.34
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



А.ЭНХГЭРЭЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайланг үе: 2018/01/01 - 2018/12/31

Үзүүлэлт	Өмч	Халвасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгэний нэмэгдэл	Галаад валютын хөрвүүлэлтийн нэмэлт	Эцсийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1 2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,949,190,711.00	18,630,191,350.00	18,630,191,350.00				557,954,261.70	23,137,336,322.70
2 Нэгтгэн болох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3 Залруулсан үлдэгдэл	3,949,190,711.00		18,630,191,350.00				557,954,261.70	23,137,336,322.70
4 Бусад дэлгэрэнгүй орлого			(1,526,387,338.06)					-1,526,387,338.06
5 Өвчдэл гаргасан өөрчлөлт								
6 Зарласан ноглол ашиг								
7 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							55,653,766.71	55,653,766.71
8 Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)								
9 2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,949,190,711.00	17,103,804,011.94	17,103,804,011.94				613,608,028.41	21,666,602,751.35
10 Нэгтгэн болох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11 Залруулсан үлдэгдэл	3,949,190,711.00	17,103,804,011.94	17,103,804,011.94				613,608,028.41	21,666,602,751.35
12 Бусад дэлгэрэнгүй орлого			4,042,111,447.40					5,734,620,736.40
13 Өвчдэл гаргасан өөрчлөлт	1,692,509,289.00							
14 Зарласан ноглол ашиг								
15 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
16 Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)								
17 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,641,700,000.00	21,145,915,459.34					830,773,878.75	27,618,389,338.09

ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ НИЯТЛАН БОДОГЧ

А.ЭНХГЭРЭЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Мөнгөн гүйлгээний тайлан

2018/01/01 - 2018/12/31

Морийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайланг жилийн дүн /тогтоогоор/
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,915,989,334.51	3,453,459,139.76
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,914,398,131.93	3,452,124,702.39
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,591,202.58	
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого		1,334,437.37
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,514,562,585.28	4,945,319,455.19
1.2.1	Ажиллагчдад төлсөн	129,287,256.20	344,937,423.93
1.2.2	Нийгэмийн даатгалын байгууллагад төлсөн	34,279,456.28	97,633,164.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	990,973,213.19	2,291,483,460.60
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	67,333,016.99	85,400,273.08
1.2.5	Түлш, шатахуун, гээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	225,325,880.95	354,661,996.94
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	1,723,841.78	237,317,414.24
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	22,024,617.74	540,310,756.17
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,592,951.00	9,707,247.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	38,022,351.15	983,867,718.56
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	401,426,749.23	-1,491,860,315.43
2	Хоронго оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	51,289.26	339,791,434.90
2.1.1	Үндсэн хоронго борлуулсаны орлого		
2.1.2	Биет бус хоронго борлуулсаны орлого		
2.1.3	Хоронго оруулалт борлуулсаны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хоронго борлуулсаны орлого		
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	51,289.26	339,791,434.90
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,133,848.00	936,976,601.08
2.2.1	Үндсэн хоронго олж эзэмшихэд төлсөн	18,333,848.00	935,626,601.08
2.2.2	Биет бус хоронго олж эзэмшихэд төлсөн	1,800,000.00	1,350,000.00
2.2.3	Хоронго оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хоронго олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хоронго оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-20,082,558.74	-597,185,166.18
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,500,000.00	8,527,568,102.37
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	8,500,000.00	2,692,475,753.42
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		5,835,063,930.00
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Валютын ханшны тэнцэтгэлийн ашиг		28,418.95
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	875,839,175.93	2,644,589,578.83

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	875,839,175.93	2,264,842,897.94
3.2.2	Санхүүгийн түрээсийн оглолт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		2,144,561.81
3.2.6	Үнэт цаас нэмж гаргахтай холбогдон гарсан зардал		377,602,119.08
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйцээний дүн	-867,339,175.93	5,882,978,523.54
4	Бүх цэвэр мөнгөн гүйцээ	-485,994,985.44	3,793,933,041.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	601,254,994.09	115,260,008.65
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	115,260,008.65	3,909,193,050.58

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ НИЯТЛАН БОДОГЧ



А.ЭНХГЭРЭЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Хэвлэсэн: 2019/01/25 21:34

Хуудас: 1/1

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2018 оны санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэл

2018 оны 12 сарын 31 өдөр

Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл, ерөнхий нягтлан бодогч Б.Нарангэрэл бид манай аж ахуйн нэгжийн 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 18.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Захирал

Ерөнхий нягтлан бодогч



/А.Энхгэрэл /

/Б.Нарангэрэл /



Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Фламинго Тауэр,
403 тоот, Улаанбаатар 14210, Монгол Улс



www.basaltwool.mn



monbasalt@rockwool.mn